

ЗУРГААН НАСТНУУДЫН СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ ШИЛДЭГ ТУРШЛАГУУДЫГ ХУВААЛЦАЖ БАЙНА

Хүүхдийг Ивээх Сан нь 2015-2018 онд Япон улсын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамтай хамтран нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын 24 сургуульд хэрэгжүүллээ. Нэгдүгээр ангид суралцагчид, ялангуяа сургуулийн өмнөх боловсролд хамрагдалгүй сургуульд элсэн орсон, захын хорооллуудын хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн сургуульд дасан зохицох болон суралцах чадварыг сайжруулах зорилготой энэхүү төсөлд нийт 204,641 хүн хамрагдаж шууд үр шимийг хүртсэн байна.

Төслийн амжилт, үр дүн:

- Бага ангийн **1,523** багшид шат дараалсан сургалтуудыг зохион байгуулав
- Эдгээр багш нар сургалтын идэвхтэй аргагүйгээр дамжуулан **65,000** гаруй хүүхдийн суралцах чадварт дэмжлэг үзүүллээ
- Сургуулиуд шинэлэг бодлоготой болж, нэгдүгээр ангийнхныг загвар сургууль болохоор зорилт тавин ажиллаж байна
- Сурагчдын суралцах үйл явцыг дэмжих олон төрлийн үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулж, тэдгээрт **46,000** гаруй эцэг эхчүүд хамрагдав
- БСШУСЯ-тай хамтран “Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөр” болон түүнд хэрэглэдэг дасгал ажлын дэвтрийг шинэчлэн боловсруулж, уг хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байна

Дээрх үйл ажиллагааг зорилтот сургуулиудад хэрэгжүүлэх явцад сургуулийн хамт олон, багш нар болон эцэг эхчүүдийн санаачилгаар хүүхдүүдийн сургуульд дасан зохицох болон суралцах чадварыг сайжруулах олон шинэлэг арга барил, туршлагауд бий болсоныг Хүүхдийг Ивээх Сан өнөөдөр танилцуулж байна. Тухайлбал, төсөлд хамрагдсан 37, 117 дугаар сургууль “Сургуультай танилцах аялал” зохион байгуулдаг болжээ. Энэ нь анх сургуульд орж байгаа хүүхдэд “үл таних ертөнц” болох сургуулийн орчныг ойртуулах, эерэг зөв сэтгэгдэл төрүүлэхэд чухал нөлөөтэй арга хэмжээ юм. 39-р сургууль 6 настай хүүхдийн тоглонгоо суралцдаг онцлогт тулгуурлан, уншлагын хөзөр - ширээний тоглоомыг ашиглаж байна. Бүх үсэг, үеийг ард талд нь хэвлэсэн хөзрийг эцэг эхчүүд хамтран бэлдэх ба хүүхдүүд чөлөөт цагаараа хөзөр тоглонгоо үсэг, үе, үгийг унших, нүдлэх, бичих чадвараа хөгжүүлдэг. Харин 17-р сургууль нэгдүгээр ангийн багш нарын ажлын ачааллыг бууруулах, хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаа зохион байгуулахад нь туслалцаа үзүүлэх зорилгоор сургуулийн бусад багш нарыг хамруулан, гарын доорх материал ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материал хийж туслах аяныг өрнүүлсэн юм. Багш нарын бэлтгэсэн даалгаврын сан, зурагт тоглоом, том жижиг ном гэх мэт олон төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн нь 6 настнуудын анхаарлыг тогтоох, мөн багш нарын хамтын ажиллагааг дэмжсэн арга хэмжээ болжээ.

Эдгээр болон бусад шилдэг арга туршлага нь зорилтот сургуулиудад тодорхой хугацаанд туршигдаж, хүүхэд, эцэг эхчүүдэд үр дүнгээ өгсөн бөгөөд зургаан настнуудыг сургуульд дасан зохицох, суралцах чадварыг сайжруулах арга замыг эрэлхийлж байгаа сургуулиуд, бага ангийн багш нар болон эцэг эхчүүдэд удирдамж болох юм.

Дэлгэрэнгүй мэдээлэл, ярилцлага, гэрэл зургийг: А.Дэлгэрмаа, Хүүхдийг Ивээх Сан, Хэвлэл мэдээллийн ажилтан delgermaa@savethechildren.mn; +(976) 88919395; +(976) 11329371 (13)

Төслийн танилцуулга болон сайн туршлагын номыг эндээс татаж үзнэ үү.

<https://www.savethechildren.mn/mn/page/mofa>

<http://bit.ly/2D0gQ9A>

СУРГУУЛИУДЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

Уулзалт 2018.03.06-ны Мягмар гаригт Крокус Эвент Холл – д болно

| Цаг | Үйл ажиллагаа | Илтгэгч |
|---------------|---|--|
| 10:00 - 10:15 | Нээлт болон мэндчилгээ | Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөрийн захирал Мицуаки Тоёода |
| 10:15 - 10:20 | Сурагчдын тоглолт | Чингэлтэй дүүргийн 17-р сургуулийн 1-р ангийн сурагчид |
| 10:20 - 10:35 | Төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх танилцуулга | Төсөлд хамрагдсан Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн бага боловсролын мэргэжилтнүүд |
| 10:35 - 10:40 | Гар зургийн уралдаанд шалгарсан бүтээлийн шагнал гардуулах | “Багшийн арга зүй” сэдвээр шалгарсан бүтээлийн эзэн |
| 10:35 - 10:50 | Багшийн заах арга зүйд гарсан өөрчлөлт, дэвшил | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 79-р сургуулийн бага ангийн сургалтын менежер Г.Чанцалдулам |
| 10:50 – 11:00 | Багш нарын үзүүлбэр | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 79-р сургуулийн багш нар |
| 11:00 – 11:05 | Гар зургийн уралдаанд шалгарсан бүтээлийн шагнал гардуулах | Сургууль хамт олны дэмжлэг” сэдвээр шалгарсан бүтээлийн эзэн |
| 11:05 -11:20 | Сургуулийн засаглал дахь өөрчлөлт, үр дүн | Чингэлтэй дүүргийн 61-р сургуулийн захирал А.Мөнхчимэг |
| 11:20 - 11:25 | Төсөлд хамрагдсан сургуулийн сайн туршлагууд | Телевизийн сурвалжлага |
| 11: 25- 11:35 | Гар зургийн уралдаанд шалгарсан бүтээлийн шагнал гардуулах | “Эцэг эхийн оролцоо, дэмжлэг” сэдвээр шалгарсан бүтээлийн эзэн |
| 11:35 - 11:50 | Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжих үйл явц дахь Эцэг эхийн оролцоо | Чингэлтэй дүүргийн 117-р сургуулийн 1-р ангиудын Эцэг Эхийн Зөвлөлийн дарга н.Зоригтбаатар |
| 11:50-12:00 | Хаалт | Төслийн менежер Хироши Окамото |
| 12:10-13:30 | Үдийн зоог болон сэтгүүлчдэд мэдээлэл өгөх | |

